



Архангай аймаг дахь Төрийн аудитын газар

УЛСЫН ТӨСВИЙН 2024 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮНД ХИЙСЭН АУДИТЫН ДҮНГЭЭС



Архангай аймгийн хэмжээнд улсын төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт 82 хувьтай байна.





Архангай аймаг дахь Төрийн аудитын газар

ЗАРИМ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭ НЬ ХУУЛЬ ЖУРАМД ЗААСАН ШААРДЛАГЫГ ХАНГААГҮЙ БАЙНА

Архангай аймгийн хэмжээнд 2024 онд улсын төсвөөс 50,547.5 сая төгрөгийн санхүүжилтийг гүйцэтгэгчид олгожээ.

Аймгийн Засаг даргад эрх шилжүүлсэн шинээр болон өмнөх оноос үргэлжлэн хэрэгжих нийт 39 төсөл, арга хэмжээнд 76,120.0 сая төгрөгийн санхүүжилтийг олгохоор төлөвлөснөөс 56,277.4 сая төгрөгийг аймгийн төрийн санд шилжүүлсэн байна. Төрийн сангаас ажлын гүйцэтгэлд үндэслэн 50,547.5 сая төгрөгийг гүйцэтгэгч нарт олгож, 5,729.9 сая төгрөгийг барьцаа хөрөнгийн дансанд төвлөрүүлжээ.



№	Харьяа ТЕЗ	Хэрэгжсэн ТАХ-ний тоо	Улсын төсвөөс 2024 онд олгох санхүүжилт	Гүйцэтгэлээр олгосон санхүүжилт	Барьцаа хөрөнгийн дансанд
1	ЗТХСайд	6	38,095.8	31,932.5	261.6
2	Боловсролын Сайд	15	18,610.2	13,357.0	1,222.3
3	ХХААХҮС	2	1,700.0	835.8	848.7
4	ГБХНХС	1	150.0	126.5	-
5	ХББОСС	2	5,950.0	838.9	19.3
6	ЭХСайд	2	448.0	393.5	12.9
7	ССАЖЗС	6	7,182.8	1,575.9	3,326.6
8	ЗГХЭГ	5	3,983.2	1,487.4	38.5
Нийт дүн		39	76,120.0	50,547.5	5,729.9



Улсын төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр төлөвлөсөн нийт арга хэмжээний 16 төсөл, арга хэмжээний эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдлыг орон нутагт үнэлэх боломжгүй байна.

№	Хуулийн код	ТЕЗ	Төсвийн хуулиар харьяа ТЕЗ-аас хэрэгжүүлэхээр эрх шилжсэн ТАХ-д		
			Тоо	Төсөвт өртөг	2024 онд санхүүжих дүн
1	V	ЗГХЭГ	1	100.0	100.0
2	XIII	БС	5	11,947.7	5,000.8
3	XV	ЗТС	2	4,054.7	1,777.4
4	XVI	ССАЖЗС	2	3,374.1	1,874.1
5	XVIII	ХХААХҮС	2	1,700.0	1,700.0
6	XX	ЭХС	2	448.0	448.0
7	XI	ГБХНХС	1	150.0	150.0
8	XII	ХББОЦС	1	450.0	450.0
НИЙТ ДҮН			16	22,224.5	11,500.3

Архангай аймагт 2024 онд шинээр хэрэгжүүлсэн 16 төсөл, арга хэмжээний эдийн засгийн үр өгөөж, нийгмийн ач холбогдол, хэрэгцээ шаардлагыг судалгаагүй байна.

Аймгийн хэмжээнд улсын төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжих ТАХ-ний худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилт 92.8 хувьтай байна.

Төсөвлөлтийн шаардлага хангаагүй 11 ТАХ-г магадлалаар хянаж төсөвт өртгийг 7,281.1 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн байна.

Дэлгэрэнгүйг тайлангаас уншина уу.
Цахим хуудас: www.audit.mn


UNDE
CONSTRU
X



Архангай аймагт улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх 37 төсөл, арга хэмжээнээс он дамжин хэрэгжих 20, тухайн онд ашиглалтад оруулах 17 төсөл, арга хэмжээ байна.



Архангай аймаг дахь Төрийн аудитын газар
April 1 · 18
Архангай аймаг дахь Төрийн аудитын газрын аудиторууд, аймгийн ГХБХСГ-ын захиалагчийн хяналтын инженерүүдтэй хамтран аймгийн төвд улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжсэн "Спортын ордны барилга" болон "Хөгжимт драмын театр"-ын барилгын ажлын гүйцэтгэлтэй танилцлаа.
See more in Video



Аймгийн хэмжээнд улсын төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн барилга угсралтын ажлын гүйцэтгэлийг хяналтын инженерүүдтэй хамтран ТЭЗҮ, зураг төсвийн дагуу газар дээр нь тулган шалгасан явцын мэдээллийг иргэд, олон нийтэд видео контент хэлбэрээр мэдээллийг түгээж ажиллав.



Барилгын ажлын бодит гүйцэтгэлийг 2025.04.05-ны өдөр газар дээр нь тулган шалгахад

Тайлант онд ашиглалтад оруулах 13 барилга байгууламжаас 4 нь гүйцэтгэгчийн буруугаас гэрээний хугацаанд хэрэгжээгүй он дамжжээ.

Гүйцэтгэгч байгууллагаас шалтгаалан төлөвлөсөн хугацаанд хэрэгжихгүй удааширч байгаа нь өртөг нэмэгдэх нөхцөлийг бүрдүүлж, хөрөнгө оруулалтын үр ашгийг бууруулж байна.



Барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын үүрэг даалгаврын биелэлт хангагдаагүй байхад 2 барилга байгууламжийг ашиглалтад хүлээн авсан байна



Тайлант онд ашиглалтад хүлээн авсан 20,923.2 сая төгрөгийн өртөгтэй 8 барилга байгууламжийг ашиглагч байгууллагууд нягтлан бодох бүртгэлд тусгаагүй байна.





Өмнөх аудитаар өгсөн шийдвэрийн хэрэгжилт 84 хувьтай байна.



Өмнөх аудитаар аймгийн Засаг дарга, ГХБХБГ, ОНӨГ-уудад нийт 2 заалт бүхий зөвлөмж, 6 албан шаардлага, 1 төлбөрийн актыг хүргүүлж, биелэлтийг албан бичгээр тооцож ирүүлсэнд тулган шалгахад барилга байгууламжийг ашиглалтад оруулах комисс үүрэг даалгаврын биелэлт хангагдаагүй 2 барилга байгууламжийг ашиглалтад хүлээн авч өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, алдаа зөрчлийг давтан гаргасан байна.

Шалгаг дагч байгуулага	Шалгагдагч байгууллагад хүргүүлсэн		Бүрэн хэрэгжсэн		Дугуу хэрэгжсэн		Хэрэгжээгүй		Биелэлт хувийн
	Шийдвэрийн тоо	Мөнгөн дүн	Шийдвэрийн тоо	Мөнгөн дүн	Шийдвэрийн тоо	Мөнгөн дүн	Шийдвэрийн тоо	Мөнгөн дүн	
Засаг даргад	4	2,024.8	2	1,499.8	1	525.0	1		68.7
ГХБХБ	2	1,096.1	2	1,096.1					100.0
ОНӨГ	3	55,007.2	2	156.7	1	54,850.5			83.3
Дүн									84.0

АУДИТЫН ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТ, ИЛРҮҮЛЭЛТ

АРХАНГАЙ АЙМГИЙН ХЭМЖЭЭНД УЛСЫН ТӨСВИЙН 2024 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ 82 ХУВЬТАЙ БАЙНА

Аудитаар нийт **26,589.1 сая төгрөгийн** зөрчил илэрснээс 5,465.4 сая төгрөгийн зөрчилд 5 албан шаардлага, 698.8 сая төгрөгийн зөрчилд хариуцлага тооцуулах 1 албан шаардлага, 20,424.9 сая төгрөгийн зөрчилд 1 заалт бүхий зөвлөмжийг аймгийн Засаг дарга болон холбогдох байгууллагуудад хүргүүллээ.




АУДИТЫН ЗӨВЛӨМЖ

АЙМГИЙН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ГАЗРЫН ДАРГАД

Улсын төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтаар ашиглалтад хүлээн авсан 20,424.9 сая төгрөгийн 7 барилга байгууламжийг ашиглагч байгууллагын бүртгэлд тусгуулах чиглэлээр холбогдох арга хэмжээг авч ажиллах

Тайланг дарга, тэргүүлэх аудиторовын 2025 оны 04 дүгээр сарын 21-ны өдрийн А/20 дугаар тушаалаар баталгаажуулан УАГ болон аймгийн ИТХ, Засаг даргад хүргүүлэв.



Монгол улс, Архангай, Эрдэнэбулган сум

2 дугаар баг, аймгийн ЗДТГ-ын байр

Утас: 70333141. Факс: +976 70333141

И-мэйл: Arkhangai@audit.gov.mn, Вебсайт: www.audit.mn